

БАТЛАВ.  
НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН  
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ИНДРА

ТӨВИЙН 5 ДҮҮРГИЙН ОРОН СУУЦНЫ ХОРООЛОЛ ДОТОРХ АВТО ЗАМЫН  
ЗАСВАРЫН АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ /НӨХӨӨС/

1. Ерөнхий зүйл	<p>1.1 Нийслэлийн төвийн 6 дүүргийн орон сууцны хороолол доторх гудамж, замуудын зорчих хэсэг дээрх нүхэн эвдрэл, төрөн хагарлыг засварлах ажил.</p> <p>1.2 Төслийн менежер нь Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын Засвар ашиглалтын хяналтын хэлтсийн дарга /хяналтын мэргэжилтнүүд/</p> <p>1.3 Ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосон өдрөөс засварын ажил эхэлнэ.</p> <p>1.4 Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хариуцах ба засварын ажилд шаардагдах гэрэлтдэг босоо тэмдэг, анхааруулах түмбэ, ажилчдын аюулгүй байдлыг хангасан жигдэрсэн ажлын хувцсыг бүрдүүлж, хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааг бүрэн хариуцан ажиллана.</p> <p>1.5 Захиалагчийн зүгээс шаардсан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаатай холбоотой шаардлагыг хангаж ажиллаагүй нэхцэлд захиалагчийн зүгээс гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авч үүнтэй холбоотой гарсан зардлыг гүйцэтгэгч хариуцна.</p> <p>1.6 Ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосон өдрөөс ажлын талбайг ашиглуулж эхэлнэ.</p> <p>1.7 Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.</p> <p>1.8 Ажлын хөтөлбөрийг 14 хоног тутам тодотгоно.</p> <p>1.9 Уг засварын ажилд талбайн болон хөдөлмөр хамгааллын инженерийг томилсон тушаалыг гэрээний бичиг баримтанд заавал хавсарган баталгаажуулна.</p> <p>1.10 Ажлын хөтөлбөрийг хугацаанд нь тодотгон ирүүлээгүй тохиолдолд 500,000 /таван зуун мянга/ төгрөгөөр торгоно.</p> <p>1.11 Чанарын баталгаат хугацаа нь уг засварын ажлыг ашиглалтад хүлээн авах комиссын акт баталгаажсан өдрөөс хойш 1 жил байна.</p> <p>1.12 Гүйцэтгэсэн ажлын барьцаа хөрөнгө 5 хувь байна.</p> <p>1.13 Засвар хийсэн нөхөөс бурийн анхны болон засвар хийсний дараах байдлын фото зургийг нэг цэгээс авч тухайн нөхөөний төв цэгийн координатын хамт гүйцэтгэлийн бичиг баримтанд хавсарган хяналтын инженерээр баталгаажуулна.</p> <p>1.14 Ажил дуусч комисс ажиллуулах тухай мэдэгдлийг гүйцэтгэлийн бичиг баримтын хамт хүчинтэйд тооцно.</p> <p>1.15 Алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 10 хувь байна.</p> <p>1.16 Ажил дуусч баталгаажсан гүйцэтгэлийн материалыг ажлын 5 хоногийн дотор сканердаж PDF хэлбэрт оруулан CD дээр хуулбарлан хяналтын инженерт хүлээлгэн өгнө.</p> <p>1.17 Гэрээ байгуулагдаж ажлын талбайг ашиглуулж эхэлснээс хойш 7 хоногт гүйцэтгэгч машин механизм, тоног төхөөрөмж, инженер техникийн ажилтнуудыг ажлын талбайд байршуулаагүй тохиолдолд захиалагч гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.</p> <p>1.18 Засварын ажлыг хугацаандаа гүйцэтгээгүйн улмаас үүссэн аливаа зам тээврийн ослыг гүйцэтгэгч байгууллага бүрэн хариуцна.</p>
-----------------	---

	<p>1.19 Гэрээт хугацаанд гүйцэтгэгч тухайн засвар хийгдэж буй замын зорчих хэсгийн бүрэн бүтэн байдлыг хангаж тээврийн хэрэгсэл саадгүй зорчих нөхцлийг бүрдүүлнэ.</p> <p>1.20 Засварын ажлыг хийж гүйцэтгэснээс хойш чанарын баталгаат хугацаанд үүссэн эвдрэлийг захиалагч байгууллагын хяналтын дор цаг алдалгүй засварлана.</p>
2. Ерөнхий төлөвлөгөө, барилгын талбайн үзүүлэлт	<p>Эдгээр авто замуудын зорчих хэсэг дээр овойлт, хагарлууд, хөлдөлт гэсэлтээс үүдсэн эвдрэл болон янз бүрийн хэмжээтэй нүхэн эвдрэл, ан цавууд трассын дагууд нийтдээ үүссэн нь тус замд урсгал засвар хийх зайлшгүй шаардлагатайг харуулж байна. Нийт гудамж замуудын трассын дагууд зорчих хэсэг нь асфальтбетон хучилттай болно.</p>
3. Ажлын цар хүрээ	<p>Энэ төрлийн засварын ажил нь замын гадаргуу дээрх нүх, үйрэлт, овойлт, хагарлууд, хөлдөлт гэсэлтээс үүдсэн эвдрэл болон бусад тухайн газар нутгийн онцлогоос шалтгаалан үүссэн эвдэрлүүдийг засварлах ажлаас бурдэнэ. Хучилтын төрөл болон хэмжээнээс шалтгаалан нөхөөсний ажлыг дараах байдлаар ангилна. Үүнд:</p> <p>Төрөл 1-эвдэрсэн хучилтын хэсгүүдийг хуулан авч оронд нь 70 мм зузаан урьдчилж хольсон халуун асфальтбетон хольцыг дээр нь дэвсэнэ. Төрөл 1-эвдэрсэн хучилтын хэсгүүдийг хуулан авч оронд нь 220 мм зузаан хольцыг дээр нь дэвсэнэ. Ингэхдээ доод 150 мм зузаан хэсгийн оронд буталсан чулуун суурь үеийг дэвсэн нягтруулж, дээд 70 мм зузаан хэсгийн оронд Төрөл 1-т дурьдсан нөхөөсийг хийнэ.</p> <p>Төрөл 3-эвдэрсэн хучилтын хэсгүүдийг хуулан авч оронд нь 520 мм зузаан үе дэвсэх ба доод 300 мм зузаан үед урьдчилж хүйтэнд тэсвэртэй хайрган материал, хайрган элс юмуу хайргархаг хөрсийг дэвсэн нягтруулж, түүний дээр 220 мм зузаантай Төрөл 1 ба 2-т дурьдсан нөхөөсийг хийнэ. Нөхөөс хийх талбай болон нөхөөсний төрлийн талаар хяналтын инженер заавар өгнө.</p> <p>Материал: Нөхөөсний төрлөөс шалтгаалан дараах материалууд шаардагдана. Үүнд:</p> <p>Төрөл 1-Битум, урьдчилан хольсон жижиг ширхэгтэй халуун асфальтбетон хольц</p> <p>Төрөл 2-Битум, урьдчилан хольсон жижиг ширхэгтэй халуун асфальтбетон хольц, буталсан чулуу</p> <p>Төрөл 3-Битум, урьдчилан хольсон жижиг ширхэгтэй халуун асфальтбетон хольц, буталсан чулуу, хөлдөлтөөс хамгаалах үеийн материал. Нөхөөсний хэмжээ, ангилал зэргээс шалтгаалан гар ажиллагаатай хийн шахуурга болон компрессор шаардлагатай. Гар алх, доргиуртай нягтруулагч болон доргиурт индуу ашиглана.</p>
4. Ажлын хил хязгаар	Төвийн 5 дүүргийн орон сууцны хороолол доторх замуудын засварын ажлын тоо хэмжээг хавсралтаар үзүүлэв. /БЗД, ХУД, СХД, ЧД, БГД/
5. Засварын ажлын зохион байгуулалт	<p>5.1 Засварын ажлын хуваарь</p> <p>Ажлыг гүйцэтгэхдээ өөрийн гүйцэтгэж байгаа ажил, явганаар зорчиж байгаа ард иргэдэд бэрхшээл учруулахгүй байхаар анхааруулах, хориглох тэмдэг, засварын ажил явагдаж буйг мэдээлэх тэмдгүүдийг засварын ажил хийгдэж байгаа орчинд зайлшгүй байрлуулна. Шөнийн цагаар гэрэлтуүлэх хэрэгсэл болон гэрэл ойлгогч түмбэ, цацуулагчтай тууз зэргийг ажлын талбайд хангалттай байрлуулах шаардлагатай. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хаах нөхцөлд холбогдох байгууллагуудад урьдчилан мэдэгдэж, түр зам гаргаж байнгын арчилгаатай байлган оршин суугчдын ая тухтай зорчих байдлыг ханган ажиллаж, зохих зөвшөөрлийг авсан байх талаар анхаарч барилгын ажлын зохион байгуулалт, хөдөлмөр</p>

	<p>хамгааллын аюулгүй ажиллагааг нарийн баримтлан ажиллах шаардлагатай. НАЗХГ-ын даргын 2016 оны А/42 дугаар тушаалаар баталсан "Авто замын барилга, засварын хяналтын инженерийн гарын авлага"-ыг баримтлан гүйцэтгэнэ. Ажил хийж байгааг анхааруулсан тэмдэг хаалтыг зохих журмын дагуу тавина.</p> <p><b>5.2 Засварын ажил гүйцэтгэх технологи</b></p> <p>Хучилтын эвдэрсэн хэсэгт нарийвчилсан үзлэг хийж, засвар хийх нүхийг геометрын зөв хэлбэр гаргаж, орчны эвдрэлгүй хэсгээс хааш хааш нь 3-5 см-ийг оруулж тэмдэглэнэ. Тэмдэглэсэн газруудыг хөрөөдөж, нехөөсний төрлийн дагуу ухаж авч гаргасан материалыг нэн даруй хаягдал болгон зайлуулж хугацаа алдалгүй өдөрт нь асфальтбетон нехөөсийг хийнэ. Ухсан хэсгүүд нь жигд, тэгш өнцөгт хэлбэртэй босоо ирмэгтэй байна. Тухайн өдөртөө багтааж хугацаа алдалгүй ухсан нүхийг дээр дурьдсан төрөл 1, 2, 3-ын аль тохиороо нехөөс хийж, дэвссэн материалын төрлөөс шалтгаалан тохирох нягтруулалтыг хийнэ. Дээр нь асфальтбетон хучилтыг дэвсэхийн өмнө суурь болон нүхний ханануудад барьцалдуулагч материал турхэнэ. Хүчин чадал өндөртэй индүүгээр асфальтбетон хучилтыг нягтруулна. Нягтруулалтыг захаас гол руу гүйцэтгэдэг бөгөөд нягтруулсны дараа зассан гадаргуу хучилтын түвшинтэй ижилхэн байх ёстой. Хэрвээ нехөөс хийх газрыг заасан гүн хүртэл ухах явцад шаардлага хангаагүй материалыг бүрэн зайлуулж дуусаагүй байна гэж үзвэл тэдгээрийг зайлуулж дуустал ухалтыг үргэлжлүүлэхийг инженер үүрэгдэж болно. Нехөөсний эхлэх болон дуусгах ажлыг нэг өдөр хийх ба янз бүрийн байршилд хийгдэх нехөөсний ажлуудыг инженертэй долоо хоногийн өмнө урьдчилан тохирсон хуваарийн дагуу хийж гүйцэтгэнэ. Нехөөсийг хийхдээ замын зөвхөн нэг эгнээг хааж гүйцэтгэнэ. Хөдөлгөөн ихтэй зам дээр нехөөс хийх нь замын ажилчид болон зочигчдод аль алинд нь аюултай тул нехөөс хийж байх үед хаалт, замын тэмдэг, туг дарцаг байрлуулах зэргээр хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авна.</p>
<b>6. Бусад</b>	<p>Нүхэн эвдрэл засварлах ажлын хэмжээг м2-аар, асфальтбетон хольцын хэмжээг тн-оор хэмжинэ. Тухайн ажлыг эхлэн хариуцсан инженер техникийн ажилтан ажлыг бүрэн дуусгаж, баримт бичгийг бүрдүүлэн ажил хүлээлцэх комисс ажиллуулж, ашиглалтанд хүлээлгэж өгнө.</p> <p>Ажлын үе шат бүрт нэг цэгээс фото зураг авч, далдлагдсан ажил бүр дээр акт бичиж, инженерээр баталгаажуулна.</p>

Тендерт оролцогч гэрээт ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай

мэргэжлийн инженер техникийн ажилчид:

Мэргэжил /онцлогууд/		Тоо	Ажлын туршлага /жил/
Инженер техникийн ажилчид	Авто замын инженер	1	1-3 дээш
	Материалын инженер	1	1 ба түүнээс дээш
	Хөдөлмөр хамгааллын инженер	1	1 жил
	Нийт	3	-

Тендерт оролцогч гэрээт ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай машин механизмууд:

No	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр	x/n	Toо	Хүчин чадал	Тайлбар
1	Усны машин	шр	1	5 тн	Өөрийн болон түрээс
2	Экскаватор /дугуйт/	шр	1	0.15-1.25 м3	Өөрийн болон түрээс
3	Автосамосвал	шр	1	7-9 м3	Өөрийн болон түрээс
4	Индүү /гелгөр булт болон хийн дугуйт /	шр	1	3,5 тн	Өөрийн болон түрээс
5	Бага оврын ачааны машин	шр	1	1-5 тн	Өөрийн болон түрээс

Тендерт оролцогч гэрээт ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжүүд:

No	Тоног төхөөрөмжийн нэр	x/n	Toо	Хүчин чадал	Тайлбар
1	Битумын тогоо /нүүдлийн/	шр	1		Өөрийн
2	Компрессор	шр	1	110м.х	Өөрийн
3	Босоо дэвхэрдэг нягтруулагч		2		Өөрийн
4	Шөнийн цагт ажиллахад ашиглах талбайн гэрэлтүүлэг	ком	2		Өөрийн
5	Гэрэл ойлгогчтой зөөврийн түмбэ, замын хаалт, зөөврийн тэмдэг, тууз, угсардаг хашаа			Хангалттай хэмжээгээр	
6	Бага оврын гар хөрс нягтруулагч төхөөрөмж	шр	2	90кг, 120кг	Өөрийн
7	Асфальтбетон зүсэгч болон чулуу зүсэгч хөрөө	шр	2	12 см	Өөрийн

Хянасан: НАЗХГ-ын Орлогч даргын

Үүргийг түр орлон гүйцэтгэгч ..... Д.Төрбилэг

ЗАХХ-ийн дарга ..... Б.Цэрэнсодном

Боловсруулсан: ЗАХХ-ийн ахлах мэргэжилтэн ..... Д.Заансүх

Ашиглалтын мэргэжилтэн ..... Б.Ганбат

2020 ОНД НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨВИЙН 5-Н ДҮҮРГИЙН ОРОН СУУЦНЫ ХОРООЛОЛ ДОТОРХ  
АВТО ЗАМЫН НӨХӨӨСНИЙ АЖЛЫН ЗАДАРГАА

<b>№</b>	<b>Дүүргүүд</b>	<b>Хэмжих нэгж</b>	<b>Тоо хэмжээ</b>	<b>Төсөвт өртөг, /сая төг/</b>
1	Баянгол дүүрэг	м2	2000	140.0
2	Баянзүрх дүүрэг	м2	3000	210.0
3	Сонгинохайрхан дүүрэг	м2	2500	175.0
4	Чингэлтэй дүүрэг	м2	2500	175.0
5	Хан-Уул дүүрэг	м2	2000	140.0
<b>Нийт</b>			<b>12000</b>	<b>840.0</b>